



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 19 өдөр

Дугаар A/62

Зуунмод

Г Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.6, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны ээлжит бус 1 дүгээр хуралдааны 17 дугаар тогтоолын 5 дахь хавсралтын 9 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Зуунмод суманд нийтийн ариун цэврийн байгууламж барих ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулах, санхүүжүүлэх эрхийг Зуунмод суманд шилжүүлсүгэй.


2. Зуунмод суманд нийтийн ариун цэврийн байгууламж барих зардал 158,000.000 (нэг зуун тавин найман сая) төгрөгийг аймгийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ю.Бямбацогт)-д зөвшөөрсүгэй.

3. Нийтийн ариун цэврийн байгууламж барих ажлыг хуулийн хүрээнд зохион байгуулан, төсвийн нэмэлт тодотголыг Зуунмод сумын төсвөөс шийдвэрлэх, нийтийн ариун цэврийн байгууламжийн ажлыг хоёрдугаар улиралд багтаан бүрэн дуусгаж, иргэд олон нийтэд улирлын чанар харгалзахгүй нээлттэй үйлчлэх ажлыг зохион байгуулахыг Зуунмод сумын Засаг дарга (Б.Хатанбаатар)-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны газрын дарга (Ж.Даш-Яйчил)-д, Бус орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Д.Саран-Эрдэнэ)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Л. ТӨМӨРЧӨДӨР



Чинхарт онхаарч,
амьсг хийж чийнээгээ
тосоллоо танишвүүр

03/28

• 4125010417



ЗУУНМОД СУМЫН ЗАСАГ ДАРГА
Б.ХАТАНБААТАР ТАНАА

ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА

41111 Төв аймаг, Зуунмод сум, Номт 1 дүгээр баг
Утас: 70273025, И-мэйл: tuv_zdtg@tov.gov.mn

2025.03.28 № 01/505

танай _____ -ны № _____ -т

Чиглэл хүргүүлэх тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит бус 1 дүгээр хуралдааны 17 дугаар тогтоолын тав дахь хавсралтын 9 дэх хэсэгт Зуунмод суманд нийтийн ариун цэврийн байгууламж барих зардлыг Зуунмод сумаас батлагдсан зураг төсвийн дагуу шийдвэрлэсэн.

Зуунмод суманд нийтийн ариун цэврийн байгууламж барих ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулах, санхүүжүүлэх эрхийг шилжүүлэх шийдвэр гарсныг үүгээр хүргүүлж байна.

Иймд нийтийн эзэмшлийн талбайд ариун цэврийн байгууламж барих газрын асуудлыг яаралтай шийдвэрлэж, хуулийн хүрээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулах, барилга байгууламжийн техникийн нөхцөлөөс шалтгаалсан болон бусад батлагдсан төсвөөс хэтэрсэн зардлыг сумын төсвийн тодотголд тусган шийдвэрлэж ажиллах нь зүйтэй.

ЗАСАГ ДАРГА


Л.ТӨМӨРЧӨДӨР



Номхон-Дамбаа
Амьсгал замын байгуулалт

03/28

БДР.



4125010254